

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН 80 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА
ХАНГАСАН БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2025/07-21-ШТА-НА

Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn
Аудитын менежер Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Ахлах аудитор З.Даваадорж
Утас: 89100230 Цахим хаяг: davaadorjz@audit.gov.mn
Аудитор С.Гансүх
Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn
Аудитор Л.Мандахнаран
Утас: 92118277 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn
Аудитор Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Аудитор Н.Гүрбазар
Утас: 921188084 Цахим хаяг: Gurbazarn@audit.gov.mn
Аудитор Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn
Аудитор Б.Ариунтуяа
Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn
Аудитор Х.Энхтуяа
Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn
Аудитор Ц.Чагнаадорж
Утас: 99387994 Цахим хаяг: chagnaadorjts@audit.gov.mn

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.khuvsgul.audit.mn

АГУУЛГА

Агуулга	Хуудасны дугаар
Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын тайлан баталгаажуулах тушаал	4
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	5
Аудитын зорилт	5
Аудитын хамарсан хүрээ	5
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	5
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	6
Аудитын хязгаарлалт	6
Үндсэн мэдээлэл	7
БҮЛЭГ 1. Аймгийн 2026 оны төсвийн төсөлд УИХ-аас баталсан орлогыг 16,603.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь орон нутгийн орлого бүрдүүлэх боломжийг бүрэн дайчилж ажилласныг харуулж байна.	8
1.1. Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээний 93.3 хувь нь аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцэж байна.	8-9
1.2. Аймгийн 2026 оны төсвийн төсөлд УИХ-аас баталсан орлогыг 16,603.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь орон нутгийн орлого бүрдүүлэх боломжийг бүрэн дайчилж ажилласныг харуулж байна.	9-12
1.3. Зарим хөтөлбөр, арга хэмжээг суурь тооцоололгүй төлөвлөсөн байгаа нь төсвийн үр ашгийг бууруулах магадлалтай байна.	12-14
БҮЛЭГ 2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын 80 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангасан байна.	14
2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын 80 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангасан байна.	14-17
2.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 70.0 хувьтай байна.	17
Аудитын дүгнэлт	18
Аудитын зөвлөмж	19
Зөрчлийн нэгтгэл	20-21
Байгууллагын санал	22
Хавсралтууд	23-26

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОХНСАХЗ	Байгаль Хамгаалах Нөхөн Сэргээх Арга Хэмжээний Зардал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗДҮАХ	Засаг Даргын Үйл Ажиллагааны Хөтөлбөр
БОАЖГ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар
ЗГ	Засгийн Газар
МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан
ОНХО	Орон Нутгийн Хөрөнгө оруулалт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХАА	Худалдан Авах Ажиллагаа
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ТАХ	Төсөл арга хэмжээ



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/32

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дахь заалт, 2023 оны А/102 дугаар тушаалаар баталсан “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөвсгөл аймгийн орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах” нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Пүрэвдорж)-т, 2026 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Л.Төмөрбаатар/-д тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Г.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-т даалгасугай.



А.ЭРДЭНЭБААТАР

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, Монгол улсын ерөнхий аудиторын 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Хөвсгөл аймгийн Засаг даргаас аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гарган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ.

Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн төсөл нь аймаг орон нутгийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн эсэх
2. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийн зардлыг үр дүнд суурилсан арга аргачлалаар, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн хэмнэлттэй үр ашигтай байхаар бодитой тооцож төлөвлөсөн эсэх
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлж, ач холбогдлоор нь эрэмбэлж, хууль журам болон эдийн засгийн үр өгөөжтэй байх шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх

Аудитын хамарсан хүрээ

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2026 оны төсвийн төлөвлөлт, орон нутгийн орлогын тооцоо, төсвийн зарлагын тооцоо, Аймгийн Засаг даргаас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн төсвийн төсөл, хөрөнгө оруулалт, ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээтэй холбогдох баримт материалуудыг хамруулав.

Орон нутгийн төсөв боловсруулахтай холбоотой аймгийн ИТХ-ын дарга, ажлын алба, Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, мэдээлэл, холбогдох баримт материал гаргуулах, авах зэргээр хамтран ажиллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУС нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчид тулгуурлан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол улсын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад тулгуурлан судалгаа, шинжилгээ, харьцуулалт, баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглаж аудитыг гүйцэтгэсэн.

Аймгийн орон нутгийн 2026 оны төсвийн төлөвлөлттэй холбоотой эрх зүйн актыг судлах, Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын газар, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн үр дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан шаардлага, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг гол шалгуур болголоо.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Ичинхорлоо, Б.Давааням, З.Даваадорж, аудитор С.Гансүх, Л.Мандахнаран, Г.Ичинхорлоо, Н.Гүрбазар, Л.Мөнх-Оргил, Б.Ариунтуяа, Х.Энхтуяа, Ц.Чагнаадорж нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын урьдчилсан судалгаа, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 17-ний өдрийн дотор гүйцэтгэж, аудитын төлөвлөгөөг Тэргүүлэх аудитораар батлуулсан.

Аудитын талбарын ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 12 дүгээр сарын 03-ны дотор гүйцэтгэж, тайлан, дүгнэлт боловсруулж ажилласан.

Аудитын тайланг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн дотор Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хүргүүлсэн.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжөөс гадна холбогдох байгууллагын саналыг тусгалаа.

**Аудитын
хязгаарлалт**

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн ИТХ-аар төсөв батлуулах тогтоолын төсөл, зардлын холбогдох танилцуулгыг ирүүлсэн нь хуулийн хугацаанд санал дүгнэлт гаргах нөхцөл боломжийг хязгаарласан.

Үндсэн мэдээлэл

Монгол улсын Засгийн газраас 2026 оны төсвийн хүрээнд дараах бодлогуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

1. Хувь хүний хөгжлийн хамгийн том МЕГА төсөл байх болно.
2. Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, хувийн хэвшилд суурилсан өсөлтийг дэмжинэ.
3. Эрчим хүчний шинэтгэлийг эрчимжүүлж, найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангана.
4. Цахим шинэчлэлийг хурдасгаж, их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэмэгдүүлнэ.
5. Засаглалын шинэчлэлийг эрчимжүүлж, олон нийтийн хяналттай, цомхон, чадварлаг төрийн албыг бүрдүүлнэ.

Засгийн газраас 2026 онд баримталсан төсвийн бодлого, чиглэлийг орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусган боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулах, баталсан төсвийг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг чиглэл болгон ирүүлсэн байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулахтай холбогдуулан орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд хангаж, татварын өр төлбөр үүсгэхгүй ажиллах, татварын мэдээллийн санг өргөжүүлэх арга хэмжээг авч ажиллах
2. Орон нутгийн төсвийн зарлагад зардлын эдийн засгийн ангиллыг баримтлах, бүтэц орон тоог оновчтой тогтоож, УИХ-аас баталсан цалингийн сан орон тооны хязгаарт багтааж ажиллах, төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмжийг бүрэн олгох, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хууль журамд нийцүүлэн төлөвлөж зарцуулах зэрэг чиглэлийг ирүүлсэн байна.

Монгол улсын Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 18-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн суурь орлогын доод хязгаарыг 59,878.7 сая төгрөг, суурь зардлын дээд хязгаарыг 77,533.3 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 2/1720 дугаартай албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн орлого, зарлагын тэнцэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №1

		/сая.төг/	
№	Үзүүлэлт	Дүн	Хувь
1	Төсвийн нийт орлого	111,203.5	100.0
1.1	Татварын болон татварын бус орлого	56,553.3	50.9
1.2	Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	36,808.5	33.1
1.3	ОНХНС-ийн шилжүүлэг	14,593.2	13.1
1.4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	66.3	0.1
1.5	Давсан орлого болон дансны үлдэгдэл	3,182.1	2.9
2	Төсвийн нийт зарлага	111,203.5	100.0
2.1	Урсгал зардал	71,441.2	64.2
2.2	Хөрөнгийн зардал	24,193.2	21.8
2.3	ОНХС	15,569.1	14.0

Орон нутгийн 2026 оны төсвийн тэнцлийг 111,203.5 сая төгрөгөөр хангасан байна. Өмнөх оны тодосгосон төсөвтэй харьцуулахад 4,200.9 сая төгрөг буюу 3.9 хувиар нэмэгдсэн байна.

БҮЛЭГ 1. Аймгийн 2026 оны төсвийн төсөлд УИХ-аас баталсан орлогыг 16,603.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь орон нутгийн орлого бүрдүүлэх боломжийг бүрэн дайчилж ажилласныг харуулж байна.

1.1. Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээний 93.3 хувь нь аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцэж байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамны 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу цаглабаруудыг баримталж ажилласан байна.

- Сумдын Засаг дарга нараас орон нутгийн төсвийн саналыг 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүлээн авсан байна.
- Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн төсөл 2027-2028 оны төсвийн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдөр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 "санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх" гэж заасны дагуу Сангийн яамнаас орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж болон төсвийн хязгаарыг ирүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн ТЭЗ-ийн 2026 оны төсвийн төслийг Засгийн газрын 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан төсвийн хязгаартай харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1.

/сая.төг/

№	Үзүүлэлт	2026 оны		
		Төсвийн хязгаар	Төсвийн төслийн санал	Зөрүү
	1	2	3	4=3-2
1	Суурь орлого	59,878.7	33,752.4	26,126.3
2	Суурь зарлага	77,533.3	131,569.6	54,036.3

Эх сурвалж: ЗГ-ын 2025 оны 01 дүгээр тогтоол, аймгийн 2026 оны төсвийн төсөл

Хүснэгтээс харахад Сангийн яаманд хүргүүлсэн төсвийн төсөл нь Засгийн газраас тогтоосон төсвийн хязгаарт багтаагүй буюу суурь зардлыг 54,036.3 сая

орлогыг төсвийн хязгаараас 26,126.3 сая төгрөгөөр бага, суурь төгрөгөөр илүү төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3¹ дахь заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсвийн төслийн саналыг Сангийн яамны хянасан дүнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 2.

/сая.төг/

№	Үзүүлэлт	2026 оны		
		Төсвийн төслийн санал	Сангийн яамны хянасан дүн	Зөрүү
	1	2	3	4=3-2
1	Суурь орлого	33,752.4	42,884.8	9,132.4
2	Суурь зарлага	131,569.6	85,451.3	(46,118.3)

Эх сурвалж: Сангийн яамны хяналтын хуудас, аймгийн 2026 оны төсвийн төсөл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн саналыг Сангийн яам хянахдаа суурь орлогыг 9,132.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зардлыг

46,118.3 сая төгрөгөөр бууруулж хянаснаас харахад төсвийн төслийг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөхгүй байгаа нь харагдаж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сан, их засвар болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд шинээр хэрэгжиж эхлэх төсөл, арга хэмжээнүүдийг "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр,

¹ жилийн төсвийн хязгаарт багтаасан байх

Аймгийн Засаг даргын үйл 2024 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хөвсгөл аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд нийцсэн эсэхийг хянаж ажиллалаа.

Монгол улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл УИХ-аар батлагдаагүй байгаатай холбоотойгоор аймгийн хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл хүлээгдэж байгаа тул аудитаар 5 жилийн үндсэн чиглэлд нийцсэн эсэхэд дүгнэлт гаргах боломжгүй байна.

Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн төсөлд 56,671.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 30 төсөл арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

Хүснэгт №2

Хөрөнгө оруулалтын төрөл	Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт			Хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн:				
				Хөвсгөл аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө:		Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг:		Хувь
	Тоо	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	11	34,832.6	16,969.4	11	34,832.6	11	34,832.6	100.0
Их засвар	3	517.1	517.1	1	175.0	3	517.1	66.7
Замын сангийн хөрөнгө оруулалт	3	3,305.5	1,924.4	3	3,305.5	3	3,305.5	100.0
Орон нутгийн хөгжлийн сан	3	17,510.0	3,255.1	3	17,510.0	3	17,510.0	100.0
БХНСАХ-ний зардал	10	506.2	506.2	10	506.2	10	506.2	100.0
Нийт	30	56,671.4	23,172.2	28	56,329.3	30	56,671.4	93.3

Хяналт хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдээс хөгжлийн бодлогын зорилтуудтай нийцээгүй дараах асуудлууд илэрч байна. Үүнд:

1. Их засварын хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих 342.1 сая төгрөгийн дараах 2 төсөл, арга хэмжээ нь Хөвсгөл аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд нийцээгүй байна. /жагсаалтыг хавсралт №1-ээс үзнэ үү/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2.5}, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4³ дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, их засвар, замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний 93.3 хувь нь аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцэж байна.

1.2. Аймгийн 2026 оны төсвийн төсөлд УИХ-аас баталсан орлогыг 16,603.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь орон нутгийн орлого бүрдүүлэх боломжийг бүрэн дайчилж ажилласныг харуулж байна.

Сангийн яамнаас Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын төслийг боловсруулахдаа бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөх талаар дараах арга хэмжээнүүдийг тусгасан байна. Үүнд:

- Орон нутгийн орлогын төсөөлөл, гүйцэтгэл, холбогдох тайлбар танилцуулгыг орлогын эдийн засгийн ангиллын дагуу бэлтгэх,

² Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна: тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх

³ орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх

- Төсвийн орлогыг эдийн засгийн суурь үзүүлэлтийн таамаглалтай уялдуулж судалгаа тооцоонд үндэслэх
- Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн ноогдол ашгийн орлогыг төлөвлөх
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу албан татвар ноогдуулах жилийн орлогын төлөвлөгөөнд үндэслэх
- Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн албан татвар, Газрын төлбөр, ойн нөөц ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж зэрэг орлогуудын тооцооллыг үндэслэлтэй тооцох зэрэг чиглэлийг өгсөн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсээс орон нутгийн 2026 оны төсвийн төлөвлөлтөд баримтлах дээрх бодлого чиглэлийг сумдын Засаг дарга нар болон байгууллагын дарга нарт хүргүүлэн ажилласан байна.

Тус чиглэлийн хүрээнд татварын болон татварын бус орлого төвлөрүүлэгч байгууллагуудын 2026 онд төвлөрүүлэх орлогын саналыг авч нэгтгэн төсвийн төслийг боловсруулсан байна.

Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн нийт эх үүсвэрийг 94,600.1 сая төгрөгөөр Улсын Их Хурлаар батлагдаж ирснийг 16,603.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 111,203.5 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьсан байна. /Орон нутгийн орлогын төлөвлөлтийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт №2-оос харна уу/

Хүснэгт 3. Орлогыг эх үүсвэрээр нь авч үзвэл:

/Сая.төг/

№	Үзүүлэлт	УИХ-аас баталсан суурь орлого	АИТХ-д өргөн барьсан	Зөрүү
1	Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	36,808.5	36,808.5	-
2	Орон нутгийн суурь орлого	43,198.4	56,553.3	13,354.9
3	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	14,593.2	14,593.2	-
4	Төсөвт байгууллагын өөрийн орлого		66.3	66.3
5	Дансны үлдэгдэл, давсан орлого		3,182.1	3,182.1
Нийт эх үүсвэр		94,600.1	111,203.5	16,603.4

Эх сурвалж: Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл

Орон нутгийн орлогыг 16,603.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь дараах голлох шалтгаантай байна. Үүнд:

- Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн орлогоос 736.7 сая төгрөгийг нэмж,
- Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 2026 оны газрын дуудлага худалдаагаар 10,000.0 сая төгрөгийн орлогыг төлөвлөсөн,
- Засгийн газрын бодлого чиглэлтэй уялдуулан цалин, хөдөлмөрийн хөлс шат дараатай нэмэгдсэнтэй холбоотой Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгах ХХОАТ-ын орлогыг 1,800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тус тус төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-д өргөн барьсан төсвийн төслийг 2025 оны тодотгосон төлөвлөгөөтэй харьцуулж үзэхэд 7,358.8 сая төгрөг буюу 15 хувиар нэмэгдүүлэн тооцсон байна.



Орон нутгийн орлогыг 2026 онд 56,553.3 сая төгрөг байхаар төлөвлөсний 6,744.4 сая төгрөг нь аймгийн орлого, 49,808.9 сая төгрөг нь сумын орлогоос бүрдэж байна.

Төсвийн саналыг аймгийн 2025 оны тодотгосон төлөвлөгөөтэй харьцуулан үзвэл 2026 оны сумын орлого 3,850.0 сая төгрөг буюу 8.4 хувиар нэмэгдсэн бол аймгийн орлого 3,508.8 сая төгрөг буюу 108.4 хувиар нэмэгдсэн байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

№	Орон нутгийн орлогын төрөл	Төлөвлөж байгаа орлогын дүн	Аудитаар:		Орлого нэмэгдүүлж аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн:
			Нэмэгдүүлэх боломжтой орлогын дүн	Саналаас орлого нэмэгдүүлсэн дүн	
1	Цалин, хөдөлмөрийн хөлс ... орлого	27,500.0	1,841.6	1,800.0	29,300.0
2	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	1,854.4	5,166.4	250.0	2,104.4
3	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого	1,410.0	198.4	11.6	1,421.6
4	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого	1,085.0	131.3	0.0	1,085.0
	ДҮН	31,849.4	7,337.7	2,061.6	33,911.0

Орон нутгийн орлого нэмэгдүүлэхээр хүргүүлсэн саналуудыг дэлгэрэнгүй тайлбарлавал:

Санал-1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого:

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2026 оны төсвийн суурь орлогыг төлөвлөхдөө Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 27,500.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Төсвийн төлөвлөлтийг хийхдээ 2026 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн багш нарын үндсэн цалинг 50 хувиар нэмэгдүүлэхээр Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг нэмэгдүүлэн тооцоогүй байна. Үүнийг тооцвол дараах байдалтай байна. Үүнд:

Орлого нэмэгдүүлэх тооцоолол.

/сая төгрөгөөр/

Утга	Дундаж үндсэн цалин 1 багшид ноогдох	Багш нарын тоо	Нийт сар	Жилийн нийт цалин	Жилд ноогдуулах татвар 10 хувь
Нэмэгдүүлээгүй цалин	1.5	2,337	12	41,617.3	3,683.1
50 хувь нэмэгдүүлсэн цалин	2.2	2,337	12	62,425.9	5,524.7
Нэмэгдүүлэх дүн					1,841.6

Эх сурвалж: <https://www.1212.mn/>

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 1,841.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт 29,341.6 сая төгрөгөөр төлөвлөх боломжтой байна.

Санал-2. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого:

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2026 оны төсвийн төсөлд 1,854.4 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого нь 2022 онд 4,982.9 сая төгрөг, 2023 онд 2,122.3 сая төгрөг, 2024 онд 13,590.9 сая төгрөг 2025 оны эхний 10 сарын байдлаар 7,387.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 2022-2024 оны гүйцэтгэл болон 2025 оны эхний 10 сарын гүйцэтгэлийн дунджаар тооцож үзэхэд тус орлогыг 5,166.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2026 оны төсвийг нийт 7,020.9 сая төгрөгөөр төлөвлөх боломжтой байна.

Санал-3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого:

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 2024 оны гүйцэтгэлээр 1,608.4 сая төгрөг, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,643.9 сая төгрөг байхад 2026 оны төсвийн төсөлд 1,410.0 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна. Тус орлогыг өмнөх оны гүйцэтгэлээр тооцож 198.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,608.4 сая төгрөгөөр төлөвлөх боломжтой байна.

Санал-4. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар:

Хөвсгөл аймаг 2025 оны Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг 1,081.0 сая төгрөгөөр төлөвлөж эхний хагас жилийн байдлаар 842.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Харин 2026 оны төсөвт дээрх татварын орлогыг 1,085.0 сая төгрөгөөр хянасан байна. Авто тээврийн үндэсний төвөөс ирүүлсэн тоон мэдээлэл, аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан “Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээ”-г үндэслэн 2026 оны Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 1,216.3 сая төгрөгөөр тогтоох буюу 131.3 сая төгрөгөөр тус орлогыг нэмэгдүүлэх саналтай байна.

Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн төсөлд нийт 7,337.7 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх саналыг хүргүүлснээс цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 1,800.0 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 250.0 сая төгрөг, хог хаягдлын хураамжийн орлого 11.6 сая төгрөг нийт 2,061.6 сая төгрөгийн саналыг хүлээн авч орон нутгийн орлогыг нэмэгдүүлэн тооцож төсвийн төслийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьсан байна.

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд УИХ-аас баталсан орлогыг 16,603.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь орон нутгийн орлого бүрдүүлэх боломжийг бүрэн дайчилж ажилласныг харуулж байна. Аудитын хугацаанд орон нутгийн орлогыг 7,337.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал хүргүүлж 2,061.6 сая төгрөгийн саналыг хүлээн авч төсвийн суурь орлогыг нэмэгдүүлсэн байна.

1.3. Зарим хөтөлбөр, арга хэмжээг суурь тооцоололгүй төлөвлөсөн байгаа нь төсвийн үр ашгийг бууруулах магадлалтай байна.

Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн зарлагын төслийг нийт 111,203.5 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна. Үүнээс урсгал зардалд 71,441.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 24,193.2 сая төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд 15,569.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн суурь зардлын төсвийг Улсын Их Хурлын баталсан зардалтай харьцуулан хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №-5

/сая.төгрөг/

Үзүүлэлт	УИХ-ын баталсан	2026 оны төсвийн төсөл	Өөрчлөлт
			УИХ-ын баталснаас
Урсгал зардал	66,977.4	71,441.2	4,463.8
Хөрөнгийн зардал	13,029.5	24,193.2	11,163.7
ОНХС	14,593.2	15,569.1	975.9
Нийт зардал	94,600.1	111,203.5	16,603.4

Улсын Их Хурлын баталсан зардлыг орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд 16,603.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, өмнөх оны давсан орлого болон дансны үлдэгдлээс 3,182.1 сая төгрөг, орон нутгийн орлогоос 13,421.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

“*Бараа үйлчилгээний бусад зардал-210901*”-д мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг хөтөлбөр тус бүрээр өмнөх онтой харьцуулж үзэхэд үр ашиггүй, хөтөлбөр нь батлагдаагүй, тооцоололгүй дараах хөтөлбөрүүд байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх “*Санхүүгийн хяналт дотоод аудит, эрсдэлийн удирдлага*” хөтөлбөрт 30.0 сая төгрөг төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 17.5 сая төгрөгөөр буюу 1.4 дахин өндөр байна. Өмнөх оны гүйцэтгэлийг хянаж үзэхэд тухайн хөтөлбөрийн зардлын 80.2 хувь нь хоол, ундны зардалд зарцуулсан байгаа нь тухайн хөтөлбөрт зарцуулсан төсвийн үр ашиггүй байдлыг харуулж байна.
- Соёл, урлагийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнд өмнөх онд 50.0 сая төгрөг тооцон төлөвлөж байсан бол 2026 оны төсвийн төсөлд 470.0 сая төгрөг тооцон төлөвлөсөн нь материаллаг хэмжээгээр буюу 8.5 дахин өссөн байна. Хэрэгжүүлэх арга хэмжээг хянаж үзэхэд ХДТ-ын ойн арга хэмжээний хүрээнд баримтат кино хийхээр 80.0 сая төгрөг тооцож төлөвлөсөн байна.
- Мал аж, ахуйн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнд нийт 1,165.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Уг арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө, тооцоолол хийгдээгүй байгаа нь төсвийн үр ашгийг бууруулах эрсдэлтэй байна. Мөн 2025 онд Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн “Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар нийт 135.3 сая төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон нь тухайн хөтөлбөрт зарцуулсан төсвийн хяналт, хэрэгцээтэй, үр ашигтай байдал ямар түвшинд байгааг илтгэж байна.
- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, арга хэмжээний зардлаар “***Хушин ойн төлөв байдал, хамгаалах арга хэмжээг тодорхойлох судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх***” арга хэмжээг 180.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хэрэгжүүлэх ажлын даалгавар, техник эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаагүй байна.

Дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоогүй, нарийвчилсан тооцоо, үндэслэл хангалтгүй, зардлыг хийсвэрээр төлөвлөсөн байдал ажиглагдаж байгаа нь төсвийн зарцуулалтын үр ашиг, бодит хэрэгцээг хангахгүй байх эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁴, 31 дүгээр зүйлийн 31.1⁵, 31.4.6⁶ дах заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Аудитаар хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас бусад зардалд хяналт хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудлууд илэрлээ. Үүнд:

- Аймгийн ЗДТГ-ын төсвийн зардлын төлөвлөгөөнд улсын их баяр наадмын зардал 300.0 сая төгрөг, ОНХС-аас 10.0 сая төгрөг, нийт 310.0 сая төгрөг төлөвлөсөн байна. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “*Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай (Наадмын санхүүжилт)*” тогтоолын 1-р зүйлд⁷ заасанд нийцэхгүй байна.
- Сумдын багийн засаг даргын орон тоог 3-аар илүү төлөвлөж, тухайн цалингийн зардалд 93.4 сая төгрөг илүү тооцож төлөвлөсөн байна.
- Аймгийн ЗДТГ-ын биеийн тамир уралдаан, тэмцээний зардалд 12.6 сая төгрөг төлөвлөсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8⁸ дах заалттай нийцэхгүй байна.

⁴ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁵ Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана

⁶ төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоо

⁷ Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай./Хавсралтад ЗГ-ын 2014-6-14-ний 194-р тогтоолоор өөрчлөлт орсон/

⁸ байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах

- Дээд шатны захирагчийн шийдвэр гараагүй байхад Мөрөн сумын “**Захирагчийн ажлын алба**”-г шинээр байгуулж, цалингийн зардалд 294.2 сая төгрөг төлөвлөсөн байна. Энэ нь Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3⁹, 10 дугаар зүйлийн 10.6¹⁰, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл¹¹, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2¹², 67.4¹³ дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

Төсвийн төслийн зардлын дүн нийт хэмжээгээр өмнөх оноос 1.6 хувиар өссөн байна. Харин зардал тус бүрээр нь өсөлтийг авч үзэхэд “бараа үйлчилгээний бусад зардал” 2025 оны тодотгосон төсвөөс 4 дахин өссөн байгаа нь Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоогүй, нарийвчилсан тооцоо, үндэслэл хангалтгүй, зардлыг хийсвэрээр төлөвлөсөн байдлаас шалтгаалсан байна.

Төсвийг төлөвлөхдөө бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэл, төсвийн үр ашигтай зарцуулалтын хувийг харгалзан дахин тооцоолж, 690.2 сая төгрөгөөр зардлыг бууруулах санал хүргүүлснээс 93.4 сая төгрөгийн саналыг хүлээн зөвшөөрсөн байна.

Орон нутгийн төсвийн төсөлд суурь тооцоо судалгаагүйгээр арга хэмжээ төлөвлөх нь санхүүжилт хүрэлцэхгүй болох, эсвэл үр ашиггүй зориулалт бус зарцуулалт нэмэгдэх, төсвийн үр дүнтэй, зохистой хуваарилалт алдагдах зэрэг эрсдэлүүдийг бий болгож байна.

Бүлэг 2: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын 80 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангасан байна.

2.1 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын 80 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангасан байна.

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах журам”-д зааснаар төсвийн хөрөнгө оруулалтууд нь хэрэгцээ шаардлагатай, холбогдох зөвшөөрлийг /ус, дулаан, цахилгаан, газрын г.мэт/ авсан, магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй, урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон, тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, олон нийтээр хэлэлцүүлэгдсэн байх шаардлагатай байдаг.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, Замын сан, Их засварын хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж хэрэгжиж буй 7 төсөл арга хэмжээ, шинээр хэрэгжиж буй 20, нийт 78,472.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 27 төсөл арга хэмжээнд 30,188.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-7: Хөрөнгө оруулалт

сая.төг

⁹ Хотод улсын зэрэглэл тогтоох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, аймгийн зэрэглэл тогтоох асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өргөн мэдүүлснээр Засгийн газар тус тус шийдвэрлэнэ

¹⁰ Хот, тосгоны захирагч нь ажлын албатай байна. Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно

¹¹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, тэдгээрээс нэр дэвшүүлж томилогдсон Засаг дарга нь 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл харьяалах хотын Зөвлөл, Захирагчийн хуулиар хүлээсэн чиг үүргийг дараах байдлаар хэрэгжүүлнэ

¹² Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд нийслэлийн Засаг даргын тамгын газар нь газар, хэлтэс, тасагтай, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна

¹³ Аймаг, сум, нийслэл, дүүргийн тамгын газрын дарга Засгийн газраас тогтоосон бүтэц, орон тооны хязгаарт багтаан тамгын газрын орон тоо, цалингийн санг тогтоож, ажилтнуудыг томилж, чөлөөлнө


Хөрөнгө оруулалтын төрөл	Шилжих ТАХ			Шинээр хэрэгжих ТАХ			Нийт	
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	2	11,081.9	4,500.0	11	34,832.6	16,969.4	13	45,914.5
Их засвар	1	882.3	282.3	3	517.1	517.1	4	1,399.4
Замын сангийн хөрөнгө оруулалт	0	0.0	0.0	3	3,305.5	1,924.4	3	3,305.5
Орон нутгийн хөгжлийн сан	4	10,343.2	2,740.5	3	17,510.0	3,255.1	7	27,853.2
Нийт	7	22,307.4	7,522.8	20	56,165.2	22,666.0	27	78,472.6

Өмнөх онуудтай харьцуулахад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хэд хэдэн тооны томоохон төсөл, арга хэмжээг 2026 онд төлөвлөсөн байна. Тухайлбал

1. Мөрөн суманд Дулааны станц барихад 25,700.0 сая төгрөг,
2. Мөрөн суманд Хүүхэд залуучуудын соёл, амралтын хүрээлэн, гадна тохижилт, жуулчны гудамж байгуулахад 8,992.6 сая төгрөг,
3. Мөрөн суманд 35 кВ, 10 кВ-ын ЦДАШ 35/0.4 кВ-ын 2х2500 кВА дэд станцын угсралтын ажил хийхэд 5,757.5 сая төгрөг,
4. Хилэнтийн гүүрнээс Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто зам дуусгалтын ажилд 1,820.6 сая төгрөг
5. 1 дүгээр багийн засмал замаас "Ирээдүй сургууль" хүртэлх хатуу хучилттай авто замын ажилд 960.5 сая төгрөгийг тус тус төлөвлөсөн байна.

Томоохон төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь эерэг үр дагавартай ч төсөл, арга хэмжээнүүдэд ногдох нийт төсөвт өртгийн 50 хувьтай тэнцэх 25,076.1 сая төгрөгийн санхүүжилт 2027 онд шилжиж байгаа нь төсвийн хүндрэлтэй одоогийн нөхцөлд эргээд төсөвт дарамт учруулах, төсөл, арга хэмжээ удаашрах, үр өгөөж нь буурах эрсдэлийг үүсгэж байна.

Аймгийн ОНХО, ОНХС, Замын сан, Их засврын хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийг төсөвлөлтийн шаардлага хангаж буй эсэхийг авч үзвэл:



Графикаас харахад хөрөнгө оруулалтын санал авч, олон нийтээр хэлэлцүүлсэн эсэхээс бусдаар орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг төсөвлөлтийн шаардлага хангаж төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл, арга хэмжээний тухайд:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон их засварын хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 35,349.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээг хууль журамд нийцүүлэн төлөвлөсөн эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон их засварын хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүдийг үнэлж эрэмбэлээгүй, хөрөнгө оруулалттай холбоотой тооцоо судалгааг хийж төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргаагүй, олон нийтээр хэлэлцүүлээгүй бол 35,174.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээнд хэрэгцээ, шаардлагын үндэслэл болсон хөрөнгө оруулалтын санал аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.1.4.2¹⁴ дахь заалттай нийцэхгүй байна. /зөрчилтэй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт №3-оос харна уу/

2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих 2,150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 2 төсөл, арга хэмжээ нь техникийн тодорхойлолтгүй байна. Үүнд:
 - a. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах /сумдад/,
 - b. Соёлын төвийн тоног төхөөрөмж /Гариалан сум/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.1¹⁵ дэх заалттай нийцэхгүй байна. /зөрчилтэй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт №3.-оос харна уу/

3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон их засварын 425.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 2 төсөл, арга хэмжээ зураг төсөвгүй байна. Үүнд:
 - a. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүслийн хад цогцолборын тохижилтын ажил”,
 - b. Их засварын 175.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зарим сумын цагдаагийн кабоны засвар”

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.2¹⁶ дахь заалттай нийцэхгүй байна. /зөрчилтэй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт №3.-оос харна уу/

Дээр дурдсан нөхцөл байдлаас үзэхэд 2026 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө хууль, тогтоомжоор тодорхойлсон төлөвлөлтийн шаардлагуудыг хангуулаагүй байна.

Замын сангийн тухайд:

Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 2,781.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд тусгаж, 524.4 сая төгрөгийг замын сангийн нөөц хөрөнгөөр төлөвлөсөн байна.

¹⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2, 3.1.3-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна

¹⁵ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна: тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх

¹⁶ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна: барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх

Замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээ нь зураг, төсөвтэй, үр ашигтай хөрөнгө оруулалтууд боловч Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3¹⁷-т орон нутгийн замын сангийн хөрөнгөөр орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг санхүүжүүлэхээр заасантай нийцэхгүй байна.

Мөн замын сангийн хөрөнгө оруулалтын Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 3.5¹⁸-д заасан авто замын сангийн тухайн жилийн төсвийг төлөвлөх, хуваарилахад баримтлах зарчмыг мөрдөж ажиллаагүй байгааг дурдах нь зүйтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн тухайд:

ОНХС-аас Хөвсгөл аймгийн орон нутгийн хөгжлийн санд 14,593.2 сая төгрөгийн орлогын шилжүүлэг батлагдсанаас аймгийн ОНХС-д 5,019.7 сая төгрөг, сумын ОНХС-д 9,573.5 сая төгрөг зарцуулахаар хуваарилсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2026 онд 2,740.5 сая төгрөгийг 4 шилжих төсөл арга хэмжээнд, 3,255.1 сая төгрөгийг шинээр эхлэх 3 төсөл арга хэмжээнд тус тус зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны А/364 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь сум өөрийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй 122 төсөл, арга хэмжээний жагсаалтыг хүлээн авч эрэмбэлж 81 төсөл арга хэмжээний саналын жагсаалтыг бэлтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2026 онд шинээр хэрэгжүүлэхээр дараах 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

- Мөрөн суманд авто замын өргөтгөл шинэчлэл хийх” - төсөвт өртөг 17,000.0 сая төгрөг
- Зураг төсөв” - төсөвт өртөг 500.0 сая төгрөг
- Аймгийн баяр наадмын зардал – 10.0 сая төгрөг

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөлттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

1. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөлтийн шатанд дараах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
 - а/ Урьдчилсан жагсаалтыг бэлтгээгүй;
 - б/ Урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй;
 - в/ Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулах;
2. “Мөрөн суманд авто замын өргөтгөл шинэчлэл хийх” төсөл арга хэмжээний зураг төсөв нь нийт 11 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд 2026 онд аль хэсгийг нь хэрэгжүүлэх нь тодорхойгүй, байршлыг тусгаагүй, төсөл арга хэмжээний зураг төсөвт магадлал хийгдээгүй байна. Энэ нь Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5 “авто зам, замын байгууламжийн зураг төсөлд эрх бүхий этгээдээр магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулан баталгаажуулсан байх”. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар хавсралттай тус тус нийцэхгүй байна.

¹⁷ Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

¹⁸ 3.5. Авто замын сангийн тухайн жилийн төсвийг төлөвлөх, хуваарилахад дараах зарчмыг баримтална,
3.5.1. төсвийн 90-ээс багагүй хувийг Авто замын тухай хуулийн 24.3, 24.4-т тус тус заасан үйл ажиллагаанд;
3.5.2. төсвийн 10 хүртэлх хувийг Авто замын тухай хуулийн 24.5-д заасан үйл ажиллагаанд.

Аймгийн ОНХС, ОНХО, Замын сан, Их засварын хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийн төсөвлөлтийн шаардлага хангасан байдлыг Төсвийн тухай хуульд заасан 6 үзүүлэлтээр хянахад 80 хувь нь шаардлага хангасан байна.

2.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 70.0 хувьтай байна.

Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №-9

№	Зөвлөмж:		Хэрэгжилтийн хувь
	Хариуцах:	Тоо	
1	Аймгийн ИТХ-д	3	60%
2	Аймгийн Засаг даргад	7	80%
	ДҮН	10	70%

Өмнөх оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож үзэхэд 70 хувьтай хэрэгжсэн байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжөөс хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга

хэмжээг төлөвлөлтийн шаардлага бүрэн хангуулж төлөвлөдөггүй зөрчил бүрэн арилахгүй байна.

Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах ёстой. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангахаар аймгийн ИТХ-ын даргын захирамжаар төсвийн хяналтын сонголыг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан байна.

Аудитын явцад орон нутгийн төсвийн суурь орлогыг нэмэгдүүлэх 2,061.6 сая төгрөг, зардал бууруулах 93.4 сая төгрөгийн саналыг хүлээн зөвшөөрүүлж, хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээнүүдийг төсөвлөлтийн шаардлага хангуулж, төсвийн үр дүнг дээшлүүлэх, хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 6 зөвлөмжийг хүргүүлж байна.

ДУГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хөвсгөл аймгийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, их засвар, замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга 93.3 хувь нь аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцэж байна.
2. Аймгийн 2026 оны төсвийн төсөлд УИХ-аас баталсан орлогыг 16,603.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь орон нутгийн орлого бүрдүүлэх боломжийг бүрэн дайчилж ажилласныг харуулж байна. Аудитын хугацаанд орон нутгийн орлогыг 7,337.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал хүргүүлж 2,061.6 сая төгрөгийн саналыг хүлээн авч төсвийн суурь орлогыг нэмэгдүүлсэн байна.
3. Орон нутгийн төсвийн төсөлд суурь тооцоо судалгаагүйгээр арга хэмжээ төлөвлөх нь санхүүжилт хүрэлцэхгүй болох, эсвэл үр ашиггүй зориулалт бус зарцуулалт нэмэгдэх, төсвийн үр дүнтэй, зохистой хуваарилалт алдагдах зэрэг эрсдэлүүдийг бий болгож байна. Аудитаар 690.2 сая төгрөгөөр зардлыг бууруулах санал хүргүүлснээс 93.4 сая төгрөгийн саналыг хүлээн зөвшөөрсөн байна.
4. Аймгийн ОНХС, ОНХО, Замын сан, Их засварын хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийн төсөвлөлтийн шаардлага хангасан байдлыг Төсвийн тухай хуульд заасан 6 үзүүлэлтээр хянахад 80 хувь нь шаардлага хангасан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Д.Пүрэвдоржид уламжлах нь:

1. Орон нутгийн төсвийг хэлэлцэн батлахдаа хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг аймгийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхэд анхаарах
2. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд заасан зарчим, шаардлагад нийцсэн төсвийн төслийг хэлэлцүүлэн батлах.

Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатар-т:

1. Төсвийн төслийг боловсруулахдаа Засгийн газраас тогтоосон төсвийн хязгаарт багтааж төлөвлөх
2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг тухай жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх.
3. Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан зураг төсөв, хүрэх үр дүнг тодорхойлсон төсөл, арга хэмжээнүүдийг тусгах.
4. Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө хүрэх үр дүнг тодорхойлж, нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслэж хэмнэлттэй байхаар төлөвлөх.

Зөрчлийн нэгтгэл

№	Үзүүлэлт	Дүн сая.төг	Санал	Зөвлөмжийн тоо	Зөвлөмжийн дүн
Төсвийн үр ашиг, үр нөлөөтэй холбоотой					
1	Засгийн газраас тогтоосон төсвийн хязгаарт багтааж төсвийн төслийг төлөвлөөгүй байна.	0		1	
2	Аудитаар тооцоход суурь орлогыг 2,061.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.	2,061.6	Орлого нэмэгдүүлэх санал хүргүүлсэн.		
3	Хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоогүй, нарийвчилсан тооцоо, үндэслэл хангалтгүй, зардлыг хийсвэрээр төлөвлөсөн, урсгал зардлыг нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслээгүй байгаагаас 93.4 сая төгрөгийн зардлыг бууруулах боломжтой байна.	93.4	Зардал бууруулах санал хүргүүлсэн.		
	НИЙТ	2,155.0		1.00	0.00
Хууль эрх зүйн нийцэлтэй холбоотой зөрчил					
4	1. Их засварын хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих 342.1 сая төгрөгийн дараах 2 төсөл, арга хэмжээ нь Хөвсгөл аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд нийцээгүй байна.	17,486.5	Хууль тогтоомжид нийцүүлж төсөл арга хэмжээг төлөвлөх	2	17,486.5
5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон их засварын хөрөнгө оруулалтаар 2026 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүдийг үнэлж эрэмбэлээгүй, хөрөнгө оруулалттай холбоотой тооцоо судалгааг хийж төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргаагүй, олон нийтээр хэлэлцүүлээгүй				
6	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих 2,150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 2 төсөл, арга хэмжээ нь техникийн тодорхойлолтгүй байна.			2	
7	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон их засварын 425.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 2 төсөл, арга хэмжээ зураг төсөвгүй байна.				

9	Замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2,781.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ нь зураг, төсөвтэй, үр ашигтай хөрөнгө оруулалтууд боловч Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 -т орон нутгийн замын сангийн хөрөнгөөр орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг санхүүжүүлэхээр заасантай нийцэхгүй байна. 2026 онд санхүүжих дүн 1,400.0 сая төгрөг	1,400.0			1,400.0
10	“Мөрөн суманд авто замын өргөтгөл шинэчлэл хийх” төсөл арга хэмжээний зураг төсөв нь нийт 11 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд 2026 онд аль хэсгийг нь хэрэгжүүлэх нь тодорхойгүй, байршлыг тусгаагүй, төсөл арга хэмжээний зураг төсөвт магадлал хийгдээгүй байна.	2,745.1			2745.1
12	Аймгийн ЗД-ын захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-заасан ОНХС-ийн төлөвлөлтийн шатанд гүйцэтгэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна	0		1	0
	НИЙТ	21,631.6		5.0	21,631.6
	НИЙТ	23,786.6		6.0	21,631.6

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:

Ирүүлсэн санал:	Тайлбар:
<p data-bbox="737 360 842 479"></p> <p data-bbox="561 504 1018 640">ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА АЗДТГ-ын, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 70383303, Факс: Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn Цахим хуудас: https://khovsgol.gov.mn/</p> <p data-bbox="561 660 1018 741"><u>2025.12.03</u> № <u>1/2581</u> танай _____-ны № _____-т</p> <p data-bbox="507 790 1072 947">Г ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН Г АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА</p> <p data-bbox="402 987 1177 1176">Хөвсгөл аймгийн орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд хүргүүлэх саналгүй, ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд цаашид анхаарч ажиллана.</p> <p data-bbox="520 1227 679 1384"></p> <p data-bbox="692 1234 1158 1424">Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар Засаг дарга Лааган Төмөрбаатар 2025-12-03 17:44:35</p>	<p data-bbox="1283 770 1468 898">Санал ирүүлээгүй байна.</p>

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, их засвар, замын сангийн хөрөнгө оруулалтын хөгжлийн бодлогын зорилтын уялдаа хангасан эсэхийг хянасан жагсаалт

/мянган төгрөг/

Төсвийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Шинэ / шилжих	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	"Алсын хараа-2050" монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн Засаг даргын үйл 2024 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Хөвсгөл аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө
Их За 1.1	АЗДТГ-ын засварын ажлын дуусгалт	шилжих	2025	2026	882,295.1	5.4.9	4.2.3.11	3.6.1.3	34
Их За 2.1	Эрүүл мэндийн төвийн засварын ажил /Их-Уул сум/	шинэ	2026	2026	117,093.8	2.2.27	2.3.1.1	2.1.1.5	тусгагдаагүй
Их За 2.2	Зарим сумын цагдаагийн кабоны засвар	шинэ	2026	2026	175,000.0	7.4	4.2.3.11	2.1.1.10	72
Их За 2.3	Цэцэрлэгийн дээврийн засварын ажил	шинэ	2026	2026	225,000.0	2.1.12	2.2.1.17	2.1.1.7	тусгагдаагүй
	Нийт				1,399,388.9				

--ooOoo--

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг хянасан жагсаалт

/мянган төгрөг/

Төсвийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Урсгал зардал, орон тоо, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан эсэх	Эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан эсэх	Зураг төсөвтэй эсэх	Техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай эсэх	Олон нийтээр хэлэлцүүлсэн эсэх
ОНХО 2.1	Дулааны станц барих /Мөрөн сум/	25,700,000.0	10,794,427.8	үгүй	тийм	тийм	шаардлагагүй	үгүй
ОНХО 2.2	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх /сумдад/	2,100,000.0	2,100,000.0	үгүй	шаардлагагүй	шаардлагагүй	техникийн тодорхойлолтгүй	үгүй
ОНХО 2.3	Мөрөн сумын 7 дугаар багийн Ус дулаан дамжуулах төв худалдаж авах	210,000.0	210,000.0	үгүй	шаардлагагүй	шаардлагагүй	шаардлагагүй	үгүй
ОНХО 2.4	35 кВ, 10 кВ-ын ЦДАШ 35/0.4 кВ-ын 2х2500 кВА дэд станцын угсралтын ажил /Мөрөн сум/	5,757,557.5	2,800,000.0	үгүй	тийм	тийм	шаардлагагүй	үгүй
ОНХО 2.5	Уурын зуухны тогооны шинэчлэл хийх /Шинэ-Идэр сум/	180,000.0	180,000.0	шаардлагагүй	шаардлагагүй	шаардлагагүй	техникийн тодорхойлолттой	үгүй
ОНХО 2.6	Уурын зуухны тогооны шинэчлэл хийх /Тосонцэнгэл сум/	180,000.0	180,000.0	шаардлагагүй	шаардлагагүй	шаардлагагүй	техникийн тодорхойлолттой	үгүй
ОНХО 2.7	Ургийн гажиг илрүүлэх аппарат /Мөрөн сум, Нэгдсэн эмнэлэг/	200,000.0	200,000.0	шаардлагагүй	шаардлагагүй	шаардлагагүй	техникийн тодорхойлолттой	үгүй
ОНХО 2.8	Диалазын аппарат /Мөрөн сум, Нэгдсэн эмнэлэг/	45,000.0	45,000.0	шаардлагагүй	шаардлагагүй	шаардлагагүй	техникийн тодорхойлолттой	үгүй
ОНХО 2.9	Эрүүл мэндийн салбарын тоног, төхөөрөмж /Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг/	160,000.0	160,000.0	шаардлагагүй	шаардлагагүй	шаардлагагүй	техникийн тодорхойлолттой	үгүй

“Хөвсгөл аймгийн орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах” гүйцэтгэлийн аудит

ОНХО 2.10	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Тариалан сум/	50,000.0	50,000.0	шаардлагагүй	шаардлагагүй	шаардлагагүй	техникийн тодорхойлолтгүй	үгүй
ОНХО 2.11	Хүслийн хад цогцолборын тохижилт	250,000.0	250,000.0	үгүй	шаардлагагүй	үгүй	шаардлагагүй	үгүй
Их За 2.1	Эрүүл мэндийн төвийн засварын ажил /Их-Уул сум/	117,093.8	117,093.8	шаардлагагүй	шаардлагагүй	тийм	шаардлагагүй	үгүй
Их За 2.2	Зарим сумын цагдаагийн кабоны засвар	175,000.0	175,000.0	шаардлагагүй	шаардлагагүй	үгүй	шаардлагагүй	үгүй
Их За 2.3	Цэцэрлэгийн дээврийн засварын ажил	225,000.0	225,000.0	шаардлагагүй	шаардлагагүй	тийм	шаардлагагүй	үгүй
ЗС 1.1	Хилэнтийн гүүрнээс Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто зам /дуусгалт/	1,820,582.8	900,000.0	шаардлагагүй	шаардлагагүй	тийм	шаардлагагүй	шаардлагагүй
ЗС 1.2	1 дүгээр багийн засмал замаас "Ирээдүй сургууль" хүртэлх хатуу хучилттай авто	960,518.7	500,000.0	шаардлагагүй	шаардлагагүй	тийм	шаардлагагүй	шаардлагагүй
ЗС 1.3	Замын сангийн нөөц	524,400.0	524,400.0	шаардлагагүй	шаардлагагүй	шаардлагагүй	шаардлагагүй	шаардлагагүй
ОНХС 2.1	Мөрөн суманд авто замын өргөтгөл, шинэчлэл хийх	17,500,000.0	2,745,076.3	шаардлагагүй	тийм	тийм	шаардлагагүй	Тийм
ОНХС 2.2	Зураг төсвийн сан	500,000.0	500,000.0	шаардлагагүй	тийм	шаардлагагүй	шаардлагагүй	Тийм
ОНХС 2.3	Аймгийн Баяр наадмын зардал	10,000.0	10,000.0	шаардлагагүй	тийм	шаардлагагүй	шаардлагагүй	Тийм
Нийт		56,665,152.8	22,665,997.9					

--ooOoo--

Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын төлөвлөгөө

/Сая.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	2026 оны суурь орлого				Аймгийн ИТХ-д өргөн барьсан нийт орлого
	Аймгаас СЯ-нд хүргүүлсэн санал	СЯ хянасан	УИХ-аас баталсан	Аймгийн ИТХ-д өргөн барьсан	
ТАТВАРЫН ОРЛОГО	33,004.3	41,048.8	40,916.8	53,185.0	53,921.7
Орлогын албан татвар	27,150.1	34,200.0	34,068.0	35,957.1	35,957.1
Хувь хүний орлогын албан татвар	27,350.1	33,300.0	33,300.0	35,189.1	35,189.1
Цалин, хөдөлмөрийн хөлс,.....орлого	23,000.0	27,500.0	27,500.0	29,300.0	29,300.0
Үйл ажиллагааны орлого	900.0	1,300.0	1,300.0	1,300.0	1,300.0
Хөрөнгийн орлого	2,450.1	3,500.0	3,500.0	3,500.0	3,500.0
Хөрөнгө борлуулсны орлого	700.0	700.0	700.0	786.6	786.6
Шууд бус орлого	300.0	300.0	300.0	302.5	302.5
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,800.0)	(1,800.0)	(1,800.0)	(1,800.0)	(1,800.0)
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	1,600.0	2,700.0	2,568.0	2,568.0	2,568.0
Хөрөнгийн албан татвар	1,355.6	1,808.5	1,808.5	1,809.3	2,173.8
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	577.2	800.5	800.5	800.50	1,005.00
Бууны албан татвар	80.8	83.0	83.0	83.8	83.8
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	697.7	925.0	925.0	925.0	1,085.0
Бусад татвар	4,498.6	5,040.3	5,040.3	15,418.6	15,790.8
Улсын тэмдэгтийн хураамж	505.5	600.0	600.0	600.0	650.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	43.8	50.0	50.0	72.8	72.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,392.4	1,410.0	1,410.0	1,421.6	1,421.6
Газрын төлбөр	188.8	410.0	410.0	10,498.9	10,818.9
Үүнээс: Газрын төлбөр	188.8	410.0	410.0	433.1	753.1
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт	-	-	-	10,065.8	10,065.8
Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,368.1	2,570.3	2,570.3	2,825.3	2,827.5
Үүнээс:					
Ойн нөөц ашигласны төлбөр	1,852.3	1,854.4	1,854.4	2,104.4	2,104.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	414.2	607.1	607.1	607.1	607.1
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	51.9	51.9	51.9	55.3	57.5
Байгалийн ургамал ашигласны төлбөр	49.8	56.9	56.9	58.5	58.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	728.1	1,816.0	2,261.6	2,531.7	2,531.7
Хувьцааны ногдол ашиг	-	-	-	5.0	5.0
Хүүгийн орлого	-	-	445.6		
Торгуулийн орлого	705.5	1,400.0	1,400.0	1,705.0	1,705.0
Төсвийн байгууллагын өөрийн орлого	-	-	-		
Түрээсийн орлого	16.0	16.0	16.0	31.2	31.2
Нэр заагдаагүй бусад орлого	6.6	400.0	400.0	790.5	790.5
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	20.0	20.0	20.0	99.9	99.9
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсаны орлого	20.0	20.0	20.0	99.9	99.9

